



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг
Утас: 70273623, И-мэйл: tuv_zdtg@tov.gov.mn

2024. 05. 08 № 02/851

танай _____-ны № _____-т

Тендерийн хугацаа сунгах тухай

ЭМЯ/20240102060 дугаартай “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Төв/” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 6 дугаар багц тендерт гомдол гарч, гомдол шийдвэрлэсэн тухай эрх бүхий байгууллагын мэдэгдлийн дагуу дахин үнэлгээ хийж ажиллах тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах (Шинэчилсэн найруулга) хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын 5.14-т зааснаар тендерийн хүчинтэй хугацааг сунгасанг мэдэгдье.

Иймд оролцогч тендерийн хүчинтэй хугацааг сунгах бол захиалагчид 2024 оны 05 дугаар сарын 08-ны дотор бичгээр мэдэгдэнэ үү.

Мэдэгдэл хүлээн авах хаяг: tuvprocurement@tov.gov.mn

Утас: 7755-3579

Хавсралт _____ хуудастай.

ДАРГА



М.ОТГОНБАТ

4124020478



**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

41100 Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар баг
Төр захиргааны II байр, Утас: 77553579,
Цахим шуудан: tuvprocurement@tov.gov.mn

2024.05.08 № 01/80
танай _____-ны _____-т

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ЦАХИМ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА,
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТЭСТ**

ЭМЯ/20240102060 дугаартай тендерийн багц 6-т оролцогч "Хасубизнес групп" ХХК-аас Сангийн яаманд гомдол гарч хянагдаж дахин үнэлэх болсон тул тус компаний нийгмийн даатгалын лавлагаа тендер нээсэн өдрийн байдлаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасан ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг нягталж өгнө үү.

Хавсралт: Сангийн яамны 2024.05.01-ны өдрийн 03/3306 дугаар "Гомдол хянасан тухай" албан бичиг

ДАРГЫН АЛБАН УУРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ТАНХУЯГ



411050200036



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.05.01 № 03/3306
танай _____ -ны № _____ -т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ЭМЯ/20240102060 дугаартай "Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Төв/" нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 6 дугаар багцад оролцсон "Хасубизнес групп" ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид "хууль" гэх/-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам"-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

"Хасубизнес групп" ХХК-ийн гомдолд тус компанийн ирүүлсэн тендерээс нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй эсэх лавлагааг цахим системээс татаж үзэхэд мэдээлэл ирүүлээгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэртэй санал нийлэхгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу "Хасубизнес групп" ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд оролцогч нийгмийн даатгалын тодорхойлолтыг хэрхэн ирүүлэх тухай тодорхой тусгаагүй байна. Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.5-д "Захиалагч цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараах журмаар ирүүлсэн тендер шалгаруулалт зарласнаас хойших мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгоно. Үүнд: 2.5.1.татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт. Уг тодорхойлолтыг оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим системээр дамжуулан авч цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбосон байх" гэж заасан.

Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээс үзэхэд 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр "Хасубизнес групп" ХХК-ийн Нийгмийн даатгалын тодорхойлолт амжилттай татагдсан байх боловч доторх мэдээлэл харагдахгүй байгаа нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим системийн шинэчлэлттэй холбоотой алдаа байж болзошгүй байх тул тус компани хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасан ерөнхий шаардлагад нийцэх эсэхийг холбогдох байгууллагаас тодруулж, нягтлан үзэх нь зүйтэй байна.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТ

Б.Тамир дорно

*Ариунтөв дагуу
иймэгдүүлж*

О.Сүх
06.

9766005819


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02/644 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Хасубизнес групп" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж. ГАНБАТ

